

МБСГ-ын судалгааны ажлын тойм

Тэргүүн дэд ерөнхийлөгч Б. Энххуяг
Мөнгөний Бодлогын Хэлтсийн эдийн засагч Н. Ургамалсүвд

Энэхүү танилцуулгын I хэсэгт 2003-2005 онуудад Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газарт хийгдсэн судалгааны ажлуудыг тоймлон, II хэсэгт 2006-2008 онуудад хийгдэх судалгааны ажлуудыг тодорхойлох болно.

I. 2003-2005 онуудад хийгдсэн судалгааны ажлууд

Орчин үеийн мөнгөний бодлого нь Төв банкуудыг судалгаа, шинжилгээний ажлыг өндөр түвшинд хөгжүүлж, онолын мэдлэг болон түүнийг амьдрал дээр туршин баяжуулсан эмперик мэдлэгийг хуримтлуулж, ирээдүйгээ харсан бодлогын алхам хийхийг шаардах болсон. Энэхүү шаардлагын улмаас Төв банкуудын судалгааны ажилд тавих анхаарал нэмэгдэж, энэ нь ч мөнгөний бодлогын хэрэгжилт, түүний сонголтод зүй ёсоор нөлөөлсөөр байна. Тухайлбал уламжлалт буюу макро эдийн засгийн нэг үзүүлэлтийн зорилтод түвшинтэй уясан мөнгөний бодлогоос татгалзан, макро эдийн засгийн бүх л нөхцөл байдлыг харгалзуулан эцсийн зорилгоо шууд онилдог мөнгөний бодлогод шилжих хандлага сүүлийн 10-н жилд мэдэгдэхүйц нэмэгдсэн.

Төв банк яагаад судалгааны ажлыг эрхлэхэд хүрдэг вэ? Төв банкны бодлогын гол хэрэгсэл болсон хүүний дохиолол бодит эдийн засагт ямар нөлөөллийг үзүүлж байгааг тогтоох шаардлага төв банкны хувьд зайлшгүй гардаг. Энэхүү нөлөөллийн эдийн засагт үзүүлэх өөрчлөлтийн цар хүрээ, цаг хугацааг тооцож олох зорилгоор хөгжингүй орны төв банкууд бодит эдийн засаг, үйлдвэрлэл, ажил олголт, төсөв, гадаад худалдаа, ханш болон мөнгөний массыг агуулсан 3-4 загварыг тооцон өөрийн бодлогын хэрэгслийн үзүүлэх нөлөөг эдгээр загваруудаас урьдчилан таамагладаг. Урьдчилан таамаглах ажлыг явуулахаас гадна урьд өмнөх эдийн засгийн макро параметруудын өнгөрсөн хандлага мөн чухал байдаг. Судалгааны ажлыг үр дүнтэй явуулахад хэд хэдэн угтвар нөхцөл зайлшгүй хэрэгтэй: судалгааг өндөр түвшинд явуулах чадалтай боловсон хүчин, өнгөрсөнг илтгэх дор хаяж 10 жилийн эдийн засаг, банк санхүүгийн салбарын тоон мэдээллийн динамик зэргийг дурьдаж болно.

2000 оноос эхлэн Монголбанк эдийн засаг болон банк санхүүгийн салбарын судалгааны ажлыг мэргэжлийн өндөр түвшинд явуулахад онцгой ач холбогдол өгч барууны орнуудад бакалавр, магистрын сургалтад тоо, статистик, эконометрик, эдийн засгийн онолын чиглэлээр боловсон хүчнээ сургах болон давтан сургахад анхаарч ирлээ. Мөн дотоодын их дээд сургуулиудыг онц сайн төгсөгчдөөс Монголбанк шалгалт авах хэлбэрээр судалгааны багаа бэхжүүлж ирсэн.

Бусад Төв банкуудтай харьцуулахад Монголбанкны судалгааны бүтэц харьцангуй бага ч гэсэн тэдний нэгэн адилаар судалгааны үйл ажиллагааны цар

хүрээг өргөжүүлэх, чанарыг нь сайжруулахад байнга анхаарал тавьж ирсэн. Монголбанкны судалгааны ажлын хүрээ болон судалгааны бүтэц 2000 оноос хойш байнга нэмэгдэж байгаа бөгөөд тэр хэмжээгээр судалгааны ажлын чанар сайжирч, судлаачдын чадвар дээшилж байгааг судалгааны ажлуудын үр дүнгээс харж болох юм. Тухайлбал судалгааны ажлуудад хэрэглэж буй эконометрик аппаратуудын хэрэглээ болон судалгааны ажлын төрөл нэмэгджээ.

Эконометрик аппаратуудын хэрэглээ

2003 оноос өмнөх судалгааны ажлуудад эконометрик аппаратуудын хэрэглээ харьцангуй бага, хэрэглэсэн ч энгийн аппаратуудыг хэрэглэж байв. Харин 2003-2005 онуудад хийгдсэн судалгааны ажлуудад хэрэглэж буй эконометрик аппаратуудын хэрэглээний төрөл болон тэдгээрийн тайлбарлалт ихээхэн сайжирсныг энд онцлон дурдмаар байна. Энэ нь нэг талаас манай орны нийгэм, эдийн засаг харьцангуй тогтворжин банк санхүүгийн салбарын санхүүгийн зуучлал өргөжсөн нь үнэлгээний үр дүнд эерэгээр нөлөөлсөн, мөн тоон мэдээллийн динамик нэмэгдэх хирээр өндөр түвшний эконометрик аппаратуудыг хэрэглэх боломж нэмэгдэж байгаатай холбоотой юм. Нөгөө талаас манай судлаачдын чадавхи дээшилж эконометрикийн өндөр түвшний аппаратуудыг аль болох оновчтой хэрэглэхийг эрмэлзэх болсонтой холбоотой билээ. 2003-2005 онуудад хийгдсэн судалгааны ажлуудын эконометрик аппаратын хэрэглээнд дараахь ахиц, өөрчлөлтүүд гарчээ. Үүнд:

1. 2003-2005 онуудад хийгдсэн судалгааны ажлуудад динамик эгнээний үнэлгээнээс илүү хүчтэй дүгнэлтүүдийг хийх боломж олгодог панел тоон өгөгдлийг ашигласан эконометрик үнэлгээнүүдийг хийх болсон нь судалгааны үр дүнг илүү хүчтэй болгосон гэж хэлж болох юм.
2. Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор гарсан бүтцийн болон гэнэтийн өөрчлөлтүүдийн нөлөөгөөр манай тоон мэдээлэл ихээхэн тогтворгүй, огцом өөрчлөлтүүд ихтэй байдаг нь үнэлгээний үр дүнг ихээхэн хүндрүүлдэг байсан. Ийм төрлийн хүндрэлүүдийг арилган үнэлгээг хийх болсон нь судалгааны үр дүнг эрс сайжруулж байна.
3. Жижиг хэмжээний загварын үнэлгээ, түүний симуляци болон прогнозыг хийж эхэлсэн.
4. Бодлогын симуляци болон загварын прогнозыг хийх болсон.
5. Систем тэгшитгэлийг тооцох болсон

Судалгааны ажлуудын хамрах цар хүрээ

2003-2005 онуудад Монголбанкнаас гүйцэтгэсэн судалгааны ажлын төрөл харьцангуй нэмэгджээ. Тухайлбал банк хоорондын зах, инфляцийн таамаглал, загварчлал, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон Төв банкны үйл ажиллагааны талаар өмнөх онуудад судалгааны ажил хийгдэж байгаагүй байна. Энд судалгааны ажлуудыг бүлэглэн тайлбарлав. 2003-2005 онуудад Мөнгөний бодлого судалгааны газар (МБСГ)-аас нийтдээ 36-н судалгааны ажил 3-н санал асуулга хийгджээ. Үүнийг бүлэглэж авч үзвэл дараах байдалтай байна(Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д үзүүлэв). Үүнд:

1. Мөнгөний бодлого

- a. Банк хоорондын зах -4
- b. Мөнгөний үзүүлэлтүүд-4
- 2. Инфляци
 - a. Инфляцийн таамаглал-2
 - b. Инфляцийн хамаарал-4
- 3. Ханш-2
- 4. Эдийн засгийн бусад сектор
 - a. Бодит сектор-5
 - b. Гадаад сектор-3
- 5. Банк, банк бус санхүүгийн байгууллага
 - a. Зээл ба хүү-3
 - b. Бусад-5
- 6. Төв банкны үйл ажиллагаа-2
- 7. Загварчлал-3
- 8. Улс орны эдийн засаг, банк, санхүүгийн салбарын талаархи иргэдийн дунд явуулсан санал асуулга судалгаа-3

1. Мөнгөний бодлогоор 8-н судалгааны ажил хийгдсэнээс банк хоорондын зах, түүний өөрчлөлт болон мөнгөний үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн талаар тус тус 4-н судалгааны ажил хийгдсэн байна. Банк хоорондын захын чиглэлээр хийгдсэн ажлууд нь банкуудийн нөөцөө оновчтой удирдах боломжийг нэмэгдүүлэх үүднээс мөнгөний бодлогын илүү уян хатан хэрэгслүүдийг шинээр хэрэглэх болсон нь банк хоорондын захын хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа болон цаашид хэрхэн хөгжүүлэх, банк хоорондын зах дээр илүүдэл нөөц түр зуурын шинжтэй хуримтлагдах шалтгаан болон Төв банкны үнэт цаас (ТБҮЦ) болон засгийн газрын (ЗГ)-н үнэт цаасны хүү, түүний хэмжээг зарлах зүй тогтол зэрэг асуудлуудыг хөнджээ. Эдгээр асуудлууд нь харьцангуй шинэ судалгааны сэдэв бөгөөд банк хоорондын захын хөгжлийг сайжруулах, идэвхжүүлэх чиглэлд судалгаа, шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх нь мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхийн чацуу банкуудын нөөцийн удирдлагыг сайжруулах нэг нөхцөл болох юм.

Харин мөнгөний үзүүлэлтүүдийн хандлагын талаархи судалгаа нь 1990-ээд оны дунд үеэс эхлэн байнга судлагдаж байсан тул харьцангуй хуучин сэдэв бөгөөд 2003-2005 онуудад хийгдсэн судалгааны ажлууд нь өмнөх судалгааны ажлуудтай харьцуулахад илүү өндөр түвшний онолын түвшинд бичигдсэнээс гадна мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлтийн хандлага болон шалтгааныг эмпирик судалгааны үр дүнгээр баяжуулан тайлбарлажээ.

Хэдийгээр мөнгөний бодлогын чиглэлээр цөөнгүй судалгааны ажил хийгдсэн боловч мөнгөний бодлогын оновчтой сонголт, мөнгөний бодлогын дамжих сувгуудын талаар судалгааны ажил хийгдэж байгаагүй байна. Энэ нь нэг талаас тоон мэдээллийн хязгаарлалттай холбоотой юм. Гэхдээ бид мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд цаашид дээрхи чиглэлүүдээр судалгаа, шинжилгээний ажлуудыг хийх шаардлагатай юм.

2. Инфляцийн чиглэлээр 6-н судалгааны ажил нийтлэгджээ. 2003 оноос өмнөх судалгаануудад инфляцийн бусад хүчин зүйлтэй хэрхэн хамаарч буй хамаарлыг эмпирик шинжилгээгээр тодорхойлохыг оролдож байсан

бол 2003-2005 онуудад үүнээс гадна инфляцийг таамаглах оролдлогуудыг хийх болсон байна. Гэхдээ зөвхөн нэг тэгшитгэлт хялбар болон динамик эгнээний загваруудыг ашиглажээ. Инфляцид макро эдийн засгийн олон тооны хүчин зүйлс төрөл бүрийн сувгуудаар дамжин нөлөөлдөг тул цаашид инфляцийн хандлагыг тодорхойлдог макро эдийн засгийн иж бүрэн загваруудыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавих нь зүйтэй юм. Ийм төрлийн загваруудыг хөгжүүлэх нь Монголбанкнаас явуулах бодлогын арга хэмжээнүүдийн нөлөөг урьдчилан тооцсон мөнгөний бодлого явуулах боломжийг нэмэгдүүлэх нь дамжиггүй. Монгол орны нөхцөлд улирлын болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан инфляцийг мах, нефтийн бүтээгдхүүний нийлүүлэлт хөөрөгдөх үзэгдэл гардаг. Иймд инфляцийн суурь хүчин зүйлс болон түр зуурын үзэгдлүүдийг ялган салгах үүднээс Монголбанк 2005 оноос эхлэн Үндэсний статистикийн газраас сар тутам зарладаг Хэрэглээний үнийн индекс (ХҮИ буюу headline inflation)-с мах, сүү, ногоо, жимс зэрэг нийлүүлэлтийн улирлын хэлбэлзэлтэй 26 бараа бүтээгдхүүн, үйлчилгээний нөлөөг хасч тооцсон суурь инфляцийг дотоод ажилдаа хэрэглэж эхэлсэн.

3. Ханшийн талаар харьцангуй цөөн тооны судалгааны ажил хийгджээ. Үүнд ханшийн тэнцвэр болон өөрчлөлтийг тодорхойлдог загваруудыг онолын түвшинд тодорхойлж, тэдгээрийн эмпирик үнэлгээг хийснээс гадна мөнгөний бодлогод ханшийн нөлөөлөх нөлөөг судалсан нь энэ чиглэлээр хийгдсэн өмнөх ажлуудаас давуу талтай болсон гэж дүгнэж болох юм.
4. Эдийн засгийн бусад сектор, ялангуяа бодит сектортой холбоотой судалгааны ажлууд харьцангуй олон хийгджээ. Тухайлбал дээрхи судалгааны ажлуудад эдийн засгийн өсөлтөд санхүүгийн сектор болон гадаад секторуудын нөлөөллийг судлахдаа онолын боломжит хувилбаруудаас өөрийн оронд тохиромжтойг сонгон, өндөр түвшний эконометрик аппаратуудыг оновчтой хэрэглэснийг харж болно. Мөн Монголын эдийн засагт чухал нөлөө бүхий зах зээлүүдийн (алт, мах, нефть, зэс, ноолуур) талаархи цаг үеийн тоймыг Монголбанк нийтэлж иржээ. Түүнчлэн хөрш Хятад улсын юаны ханшийн болзошгүй өөрчлөлтийн манай эдийн засагт үзүүлж болох нөлөөллийг урьдчилан тодорхойлохыг оролдсон, далд эдийн засгийг хэмжих, түүний нөлөө болон өсөлтийн талаар тус тус авч үзсэн нь судлаачдын сонирхлыг ихээхэн татсан. Мөн бодит секторээс гадна гадаадын шууд хөрөнгө оруулалтын талаар судлаачид илүү сонирхож судалсан байна.
5. Банкны системийн талаар хийгдсэн судалгааны ажлууд нь сүүлийн жилүүдэд банкны салбарын хөгжилд гарсан өөрчлөлт, тэдгээрийн шалтгаан болон цаашид хөгжүүлэх талаар хөндсөн байна. Тухайлбал улсын өмчийн банкуудын хувьчлал сүүлийн 6-н жилийн дотор эрчимтэй явагдсаны дүнд банкны секторт гадаадын өмчлөл ихээхэн нэмэгдэж, тэр хэмжээгээр тэдгээр банкуудын менежементийг сайжруулсаны дүнд ашигт ажиллагаа нь нэмэгдсэнийг тэмдэглэсэн байна. Мөн банкны салбарын ашигт ажиллагааны хандлага болон татварын орчинг судалж, татварын орчин тийм таатай бусаас гадна банкууд татвараа бодит ашиг,

орлогын хэмжээгээрээ биш урьдчилсан төлөвлөгөөгөөр төлдөг нь банкуудад тодорхой хэмжээгээр дарамт үзүүлдэг болохыг тодорхойлжээ. Банкуудын панел тоон мэдээллийг ашигласан үнэлгээгээр банкууд хүүгээ өсгөхөөс илүүтэйгээр тусгай урамшуулал зарлах замаар хадгаламжийн хэмжээгээ харьцангуй бага зардлаар нэмэгдүүлэх боломж байгааг харуулжээ.

6. Хэдийгээр ашиг орлого олох эцсийн зорилгогүй ч ихэнх Төв банкууд ашигтай ажилладаг. Монголбанкны хувьд ч гэсэн үйл ажиллагаанаасаа тодорхой хэмжээний цэвэр орлого олдог бөгөөд энэхүү цэвэр орлогыг бүрдүүлж буй бүрдэл хэсэг, тэдгээрийн динамик өөрчлөлтийн талаар авч үзэхийн чацуу мөнгөний бодлогыг ямар өртгөөр хэрэгжүүлж буйг тодорхойлохыг оролдсон.
7. 2003 онд Мөнгөний бодлого судалгааны газар (МБСГ) дээр мөнгөний үзүүлэлтүүдийн загварыг хөгжүүлсэн нь загварчлалын чиглэлээр хийгдсэн анхны ажил болсон. Энэхүү загварын үнэлгээ болон симуляци хийх алхамуудыг 2003 оноос хойш 3-н удаа шинэчлэн хийсэн бөгөөд прогнозчлолыг 2005 оны байдлаар нэмж хийсэн. Энэхүү загвар нь манай орон шиг тоон мэдээлэл (мөнгөний болон банкны секторээс бусад секторуудын хувьд)-н хязгаарлалт ихтэй орны хувьд мөнгөний бодлогын нөлөөлөл, ялангуяа бодлогын хэрэгслүүдийн нөлөөг харьцангуй сайн харуулсан загвар болж чадсан гэж дүгнэж болох юм. Гэхдээ мэдээжийн хэрэг илүү сайн мэдээллийн эх үүсвэрийг бий болгож, хөгжүүлж чадвал макро эдийн засгийн бүх л секторуудыг хамарсан иж бүрэн загварыг хөгжүүлж, мөнгөний бодлогын нөлөөллийг судлах нь бид бүхний эцсийн зорилго болохыг энд дурдах нь зүйтэй болов уу.
8. МБСГ-аас Монгол улсын нийгэм, эдийн засаг, банк санхүүгийн байгууллагын хөгжил, тэдгээрийн үйл ажиллагаа сэдвээр хот, хөдөөгийн иргэдээс санал асуулгыг 2003 болон 2005 онуудад тус тус давтан явуулсан. Судалгааны гол зорилго нь улс орны нийгэм, эдийн засгийн байдал болон банк, санхүүгийн байгууллагын талаар иргэдийн санал бодол хэр өөрчлөгдөж буйг тодорхойлоход оршдог. Цаашид бид мөнгөний бодлогын судалгаа шинжилгээнд шаардлагатай иргэдийн болон зах зээлийн хүлээлтийг судлахдаа иймэрхүү түүвэр судалгааг тогтмол явуулах шаардлагатай юм.

Дээрх ангилалаас харахад өнгөрсөн гурван жилд хийгдсэн судалгааны ажлуудын ихэнх нь банк хоорондын зах болон мөнгөний үзүүлэлтүүдийн хандлагыг тодорхойлох, инфляцийн өөрчлөлт болон эдийн засгийн өсөлт түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлахад чиглэсэн ажлууд зонхилон хийгджээ.

Судалгааны ажлуудыг ерөнхийд нь дүгнэхэд тухайн үеийн нөхцөл, хэрэгцээнээс урган гарсан судалгааны ажлууд зонхилох хандлагатай байжээ. Цаашид судалгааны ажлыг зөвхөн тухайн үеийн хэрэгцээнээс үндэслэн хийхээс гадна ирээдүйн мөнгөний бодлогын зорилго, хэрэгжилт, түүний өөрчлөлттэй уялдуулан урьдчилан төлөвлөн ул суурьтай системчлэн хийхэд Монголбанк анхаарах болно. Мөн нөгөөтэйгүүр манай судалгааны ажлуудад байгаа нэг дутагдалтай зүйл нь өмнө нь хийгдэж байсан судалгааны түүх (гадаадад болон

дотоодод) болон тухайн судалгааны ажлын ялгагдах онцлог нь юу болохыг тэр бүр тодорхой бичихгүй байгаа явдал юм. Хугацаа өнгөрөх тусам судалгааны ажлуудын тоо, хэмжээ нэмэгдэж байгаа нь бие биенээсээ ялгагдахгүй ижил төрлийн судалгааны ажлуудыг давхардуулан хийх эсвэл өмнөх судалгааны ажлуудыг хуулбарлах зэргээр зохисгүй алхамуудыг нэмэгдүүлж болох талтай тул цаашид энэ тал дээр манай судлаачид илүү их анхаарал тавьж, ишлэлийг зөв хэрэглэж сурах нь зүйтэй болов уу.

II. 2006-2008 онуудад Мөнгөний бодлого судалгааны газарт хийгдэх судалгааны ажлууд, тэдгээрийн үндэслэл шаардлага

Одоогоор Монголбанк Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-г өөрийн бодлогын гол хэрэгсэл болгон ашиглаж байгаа. Арилжааны банкууд иргэд бизнес эрхлэгчдээс татсан эх үүсвэр болгоныг эргүүлэн зээл болгохыг урьтал болгохгүй байгаагаас банкуудын илүүдэл нөөц ихтэй орчинд ТБҮЦ тэр болгон эдийн засагт хүүний дохиог өгч чадахгүй байгаа, мөн ТБҮЦ-д Монголбанкнаас төлдөг хүүгийн зардал жил ирэх тутам өсч байгаа зэрэг нь сүүлийн үед Монголбанк мөнгөний бодлогын альтернатив загваруудыг судлахад түлхсэн.

Дэлхийн нийтээр инфляцийг онилох (inflation targeting) мөнгөний бодлогын загварыг өргөн хэрэглэх боллоо. Инфляцийг онилох мөнгөний бодлого¹-д шилжихэд тавигддаг урьдчилсан нөхцлүүдийг манай орны хувьд хангаж байгаа болон мөнгөний бодлогын оновчтой хувилбар байж чадах эсэхийг тодорхойлсны үндсэн дээр Монголбанк шилжих боломжтой эсэхийг судлах шаардлага Монголбанкны өмнө тавигдах боллоо.

Одоогийн ашиглаж буй загвараа сайжруулах, тооцох тэгшитгэлийн хамрах хүрээг өргөжүүлэх, макро түвшинд нөлөөлж болох хүчин зүйлсийг шинээр нэмэх зэргээр загварын таамаглах хүчин чадлыг сайжруулахаас гадна Монголбанкны Захирлуудын Зөвлөлөөр ТБҮЦ-ны хүүг өөрчлөх шийдвэр гарах тухай бүрт хүүний түвшинд өөрчлөлт гарах болсон учир шалтгаан, гарснаас бодит сектор, банк санхүүгийн салбарт үзүүлэх болзошгүй нөлөө зэргийг загварын симуляцийн дүнг хэлэлцэх маягаар ёсчлох шаардлага байна.

Мөн түүнчлэн загваруудыг нэгэнт тооцсоны дараа улирал тутам тооцооллыг шинэчлэх, мөн загварын эндоген хувьсагчдыг прогнозлох зэргээр судалгааны багийн хийх ажлын хэмжээ болон ачаалал нэмэгдэх тул судалгааны аппаратыг ч гэсэн тохируулан өргөтгөн чадваржуулах шаардлагатай болов уу. Нөгөөтэйгүүр энэ чиглэлээр хүнээ сургах, бусад Төв банкуудын туршлагаас суралцах нь

¹ *Инфляцийг онилох мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг Төв банк нэгдүгээрт дунд хугацаанд инфляцийг ямар түвшинд барихаа тодорхойлон, энэхүү урьдчилан тодорхойлсон зорилгодоо хүрэхийн тулд завсрын зорилтуудыг ашиглахгүйгээр бодлогын хэрэгслүүдээ шууд өөрчлөх замаар мөнгөний бодлогоо хэрэгжүүлдэг. Хоёрдугаарт мөнгөний бодлогын алхамууд нь бодлогын эцсийн зорилгод хугацааны хоцролттой нөлөөлдөг тул инфляцийг онилох бодлого нь дунд хугацааны инфляцийн прогнозыг хийж, түүн дээрээ үндэслэн урьдчилан-харсан бодлогын алхамуудыг хийдэг. Эцэст нь инфляцийн зорилгод түвшинг хэрхэн хангасан талаархи мөнгөний бодлогын гүйцэтгэлийг дүгнэн, түүн дээрээ үндэслэн ирээдүйн мөнгөний бодлогын алхамуудыг хэрхэн өөрчлөх талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх замаар зах зээлийн хүлээлтэд нөлөө үзүүлдэг.*

чухал. 2005 оноос эхлэн Монголбанк Польшийн Төв банктэй энэ чиглэлээр хамтран ажиллаж байна.

Мөнгөний бодлогын дамжих сувгуудад хүүгийн, зээлийн, ханшийн гэсэн гол гурван сувгийг онолын эх сурвалж нэрлэдэг. Инфляцийг онилох мөнгөний бодлогод шилжихэд хийгдэх дараагийн гол ажил нь мөнгөний бодлогын нөлөөллийн сувгуудыг Монголын эдийн засгийн хувьд тодорхойлон тооцож явдал юм. Өмнө дурдсанчлан тоон мэдээлэл хязгаарлагдмал байдгаас энэ төрлийн судалгааны ажлууд бараг хийгдэж байгаагүй билээ. Жишээ нь, зээлийн хүүгийн өртгийг өөрчлөх замаар бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын шийдвэрт төв банк хэрхэн нөлөөлж буйг тандах зорилгоор томоохон аж ахуйн нэгжүүдийн улирал тутмын тайлан тэнцлийг ихэнхи төв банкууд авч нэгтгэдэг бол татварын орчноос шалтгаалан данс хөтлөлт бүртгэл манайд хуудуу байдаг тул мөнгөний бодлогын зээлийн сувгийг ажиглах бололцоо Монголбанкны хувьд байсангүй. Гэсэн хэдий ч энэ чиглэлээр хийгдэх судалгааны ажлуудын үндэс суурийг тавьж хөгжүүлэх алхамыг хийхгүй бол шаардлагатай тоон мэдээллийг нь цуглуулах, динамикийг бий болгох алхам мөн л хойш тавигдсаар байх болно. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дарамт борлуулалтын орлого багатай бизнесийн нэгжүүдийн хувьд 2007 оноос 10 хувь болж буурах нь орлогоо нуун дарагдуулах үзэгдлийг хязгаарлан өөрсдийн орлогыг үнэн зөв мэдүүлж эхлэх хөрсийг бүрдүүлэх тохиолдолд Монголбанк дотоодын 50 том аж ахуйн нэгжийн тайлан тэнцлийг улирал тутам нэгтгэн зээлийн хүүгийн сувгийн нөлөөг тооцож эхлэх бололцоо бүрэлдэх болно. Үүний хажуугаар зээлийн олгосон хүү, үйлдвэрлэгчийн үнийн индекс болон импортын барааны үнийн индекс зэрэг зарим мэдээллүүдийг тооцох, цуглуулах эхний алхамуудыг Монголбанкнаас хийх болно. Одоогийн мэдээллийн түвшинд мөнгөний бодлогын нөлөөллийн сувгуудаас ханш, хүү болон зээлийн сувгуудыг 2006-2008 онуудад багтаан судлахаар төлөвлөж байна. Монголын эдийн засгийн потенциал болон бодит үйлдвэрлэлийн зөрүү (output gap) нь инфляцийн болзошгүй дарамтыг илэрхийлэх гол үзүүлэлт учир үүнийг зөв тооцон загвартаа ашиглах том ажил Монголбанкны өмнө тавигдана.

Инфляцийг онилох мөнгөний бодлогын загварын гол онцлог нь Төв банк олон нийтийн өмнө нээлттэй, ил тод байхаас гадна бодлогын дараагийн алхамуудын талаархи мэдээллийг зах зээлд тархаах замаар тэдний инфляцийн хүлээлтэд нөлөөлдөг. Үүний тулд ихэнх Төв банкууд инфляцийн тайланг улирал бүр нийтлэн олон нийтэд тархаадаг. Инфляцийн тайланд эдийн засаг, банк санхүүгийн салбар, үнийн ерөнхий хандлага, инфляцийн өрнөлийн талаархи төв банкны байр суурь болон мөнгөний бодлогын алхамуудын тайлбаруудыг нийтэлдэг. Хөгжингүй орнуудын төв банкны инфляцийн тайланд өмнөх инфляцийн учир шалтгааныг тайлбарлаад дараагийн 1-3 жилийн хугацаанд төв банк инфляцийг барих бодлогын зорилтыг зарлан, энэ зорилтод хүрэхийн тулд төв банкнаас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэрэгслийг ил тодоор зарладаг. Инфляцийн тайланг энгийн, ойлгомжтой, нээлттэй байлгах нь Төв банкны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд бизнес эрхлэгчдийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлнэ. Инфляцийг онилох мөнгөний бодлогын загварт шилжих тохиолдолд Монголбанк өөрийн инфляцийн тайланг хэвлэх, түүний дизайныг боловсруулах, түүнд шаардлагатай тооцоог гүйцэтгэх ажлыг зохион байгуулах шаардлага урган гарна. Инфляцийн таамаглалын тархалтын магадлалыг төв банкууд fan chart график дүрслэлээр харуулдаг.

Төв банкууд инфляци өнөөдөр хэд байна гэхээсээ маргааш хэд болтлоо яаж өөрчлөгдөх вэ гэдэгт санаа зовнидог нь мөнгөний бодлогыг ирээдүйг (forward-looking) чиглэсэн хэв загварт оруулдаг. Бусад Төв банкуудын туршлагаас харахад хэд хэдэн загваруудаар нэгэн зэрэг инфляцийн таамаглалыг үйлдэн хооронд нь харьцуулах замаар бодлогын шийдвэр гаргахад гол мэдээлэл болгон ашигладаг. Монголбанкны хувьд ч гэсэн 2-оос дээш тооны загваруудыг ашиглах нь зүйтэй гэж үзсэн. Өөрийн орны тоон мэдээлэл болон загварчлалын талаархи туршлага дээрээ үндэслэн макро эдийн засгийн жижиг болон дунд хэмжээний бүтцийн 2 загвар болон динамик эгнээний (бүтцийн бус) загваруудыг ашиглах боломжтой юм. Сайн загварыг бий болгоход судлаачдаас өндөр түвшний онолын мэдлэг шаардахаас гадна энгийн хамаарал бүрийг эмпирик байдлаар шалган баталгаажуулах, турших, хөгжүүлэхийг шаардсан тэдний урт хугацааны уйгагүй хөдөлмөрийн үр дүн байдаг. Тиймд энэхүү загварчлалын ажил нь ч гэсэн нэг удаагийн алхамаар эцэслэн тодорхойлогдохгүй, жилээс жилд сайжруулан боловсронгуй болох үйл ажиллагаа байх болно.

Монгол нь жижиг, нээлттэй эдийн засаг тул ханш, төлбөрийн тэнцэл зэрэг сувгаар дамжин гадаад орчин Монголын эдийн засагт ихээхэн нөлөөлдөг. Ганц жишээг дурьдахад төгрөг, америк долларын номиналь ханшийн өөрчлөлт нь дотоодын инфляци болон мөнгөний масст түргэн нөлөөг үзүүлдэг болох нь судалгаагаар батлагдсан. Дэлхийн зах зээл дээрхи манай экспортын бүтээгдхүүний үнийн хэлбэлзлийн болзошгүй нөлөөг Монголбанкнаас байнга таамаглах, гарч болзошгүй үр дагаврыг урьдчилан хэмжих гэнэтийн үнийн хэлбэлзлийг саармагжуулах, урьдчилан бэлтгэх бололцоог олгоно.

Гадаадад ажиллагсдын гуйвуулгын үнэн хэмжээг олж тодорхойлох, төгрөгөөр мөнгөний бодлого явуулахад эдийн засаг дахь долларжилт болон бусад гадаадын валютын хэрэглээ садаа болдог нь Монголын эдийн засагт эргэлдэж буй гадаадын мөнгөн тэмдэгтийн хэмжээ, цар хүрээг тодорхойлохыг шаардаж байна.

Монголын эдийн засагт чухал нөлөө бүхий зах зээлүүдийн (алт, нефть, зэс, ноолуур) талаархи тоймоо цаашид ч Монголбанк шинэчлэн нийтлэх болно. Эдийн засаг дахь зээлийн хүү өндөр байгаа учир шалтгааныг банкуудын тэнцэл болон орлого зарлагын тайлангаас хайх зорилгоор Мөнгөний бодлого судалгааны газар Хяналт шалгалтын газартай хамтран энэ чиглэлийн судалгаагаа эрчимжүүлэх болно.

Сүүлийн жилүүдэд банкны бус санхүүгийн зуучлал өргөжих болсон, мөн хөрөнгийн зах идэвхижих эхний шинж орсонтой уялдуулан банк, Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)-г оруулан санхүүгийн тоймыг гаргах бололцоог Монголбанк судлах болно.

Төрийн бодлого УИХ-н сонгуулийн бүрэн эрхийн дөрвөн жилийн хүрэнээс төдийлэн хальж чадахгүй байгаа жишгийг эвдэн үндэсний хөгжлийн загвар, арга замыг судлан тогтоож тулгамдсан асуулуудаар эрх баригчдад цэгцтэй, судалгаатай үнэлэлт дүгнэлтээр зөвлөх үүрэг бүхий Үндэсний хөгжлийн нэгжийг think tank-н хэлбэрээр Сангийн яам, Монголбанк дундаа байгуулах саналыг дэвшүүлж байна.